



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 502

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн  
төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүнийг  
чөлөөлөх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Барилга, хот байгуулалтын яамны Газрын дарга Б.Гүнболд, Барилга, хот байгуулалтын яамны Статистик мэдээлэл, технологийн хэлтсийн дарга Н.Нарантуяа, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хорооны дарга Ж.Батсуурь, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын ахлах зөвлөх С.Энхцэцэг нарыг “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнээс 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн чөлөөлсүгэй.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

133006187

27-r huraldaan.docx